



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 06

Есөнбулаг сум

**Зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн  
батлах тухай**


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Түмэннасан/-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 03-р сарын 07-ны өдрийн 14-р тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 20.17  
оны 02-р сарын 10-ны өдрийн 06-р  
тогтоолын хавсралт

АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн ИТХ-ын дарга  
Нарийн бичгийн дарга: Аймгийн Цагдаагийн газрын дарга

- Гишүүд: - Аймгийн Засаг дарга
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Говь-Алтай аймаг дахь Эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч
- Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор
- Онцгой байдлын газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Тагнуулын хэлтсийн дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга
- Шүүхийн шинжилгээний албаны дарга